



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/82

Мандалговь

2020 оны "Гэрийн сайн багш" алдаршуулах
үйл ажиллагаа зохион байгуулах тухай

Ахмад настны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төсвийн шууд захирагчаас Төрийн жинхэнэ албан хаагчтай байгуулсан 2020 гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.3 заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхэд залууст авъяас мэргэжлээ өвлүүлэх талаар санаачлагатай ажилласан ахмадуудаа идэвхжүүлэх зорилгоор "Гэрийн сайн багш" шалгаруулах, шагнаж урамшуулах арга хэмжээг 2020 оны 12 дугаар сард зохион байгуулсугай.

2. "Гэрийн сайн багш" шалгаруулах, шагнаж урамшуулах үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 300.000 (Гурван зуун тавин мянган) төгрөгийг нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч (Б.Бүжинлхам), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, (Б.Бүжинлхам)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

481190115